

Засгийн газрын өр хариуцсан мэргэжилтэн, Тамир Мөнхцэцэг

2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭС-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| №   | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ  | Шалгуур үзүүлэлт                              | Гүйцэтгэлийн түвшин   |   |  |  |                 |
|---|---|---|---|---|--|--|-----------------|
|   |   |   | Суурь түвшин  | Хүрэх түвшин  | Хүрсэн түвшин / биелэлт  | Эхэлсэн, дууссан хугацаа   | Биелэлтийн хувь |
|   | 1   | 2   | 3   | 4   | 5  | 6  | 7               |
| 3.1. Макро эдийн засгийн судалгааг хийж, эдийн засгийн тэнцвэрт байдал, үр ашгийг нэмэгдүүлэх бодлогын тэргүүлэх чиглэлийг тодорхойлох; |   |   |   |   |  |  |                 |
| 1   | Монгол Улсын эдийн засгийн хөгжлийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлж дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт тусгаж, бодлого зохицуулалтаар хангана. | Эдийн засгийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлох | Монгол Улсын Их Хурлын 2024 оны 35 дугаар тогтоол "Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө" батлагдсан. | Монгол Улсын 2026 оны эдийн засгийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлж танилцуулгад тусгах.<br>/1 танилцуулга / | Монгол Улсын эдийн засгийн хөгжлийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлох нь улс орны урт хугацааны хөгжлийн бодлого, стратеги, төлөвлөгөө, макро эдийн засгийн үнэлгээ, шинжилгээ, дотоодын нөөц боломж, үндэсний эрх ашиг, хөгжлийн тулгамдсан асуудлуудтай уялдан олон шат дараалалтайгаар хийгддэг цогц үйл явц юм. Монгол Улсын хөгжлийн 2026 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэл нь "ХҮН ТӨВТЭЙ" хөгжлийн үзэл санаанд нийцсэн "ЭДИЙН ЗАСГИЙН ЭРХ ЧӨЛӨӨГ ЦОГЦЛООХ"-ыг зорьж төсвийн зардлын реформ, төрийн албаны реформ, үндэсний баялгийн сан, төрийн өмчит компанийн засаглалын реформыг хэрэгжүүлэх бөгөөд тус реформууд нь ядуурлыг бууруулахад чиглэгдэнэ. Эдгээр чиглэлүүд нь Монгол Улсын эдийн засгийг төрөлжүүлэх, | 1-р сар,<br>2-р сар,<br>3-р сар,<br>4-р сар,<br>5-р сар,<br>6-р сар,<br>7-р сар,<br>8-р сар,<br>9-р сар,<br>10-р сар,<br>11-р сар,<br>12-р сар | 100%            |

|   |  |   |  |  |   |  |             |
|---|--|---|--|--|---|--|-------------|
|   |  |   |  |  | <p>тогтвортой өсөлтөд хүргэхэд чиглэсэн цогц арга хэмжээнүүдийн үндэс болдог. Дунд хугацааны баримт бичгүүдэд эдийн засагт үр өгөөжөө өгөхүйц томоохон төсөл хөтөлбөрүүдийг дэмжих зорилгоор Төсвийн урсгал зардлыг танаж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх бодлого баримталсан.</p> <p style="text-align: right;">Хавсралт: 1 файл</p>   |  |             |
| <p>3.2. Эдийн засгийн тогтвортой байдлыг хангах бодлогыг тодорхойлох, макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн төсөөлөл хийх</p> |  |   |  |  |   |  |             |
| 2   | <p>Монгол Улсын 2026 оны хөгжлийн төлөвлөгөө боловсруулахад шаардлагатай макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн тооцоо, төсөөллийн танилцуулгыг боловсруулна.</p> | <p>Тооцоо, төсөөллийн тусгасан танилцуулгын тоо</p> | <p>Монгол Улсын Их Хурлын 2024 оны 35 дугаар тогтоол "Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө" батлагдсан.</p> | <p>Эдийн засгийн 2026 оны тооцоо төсөөлөл, танилцуулга бэлтгэх /1 танилцуулга/</p> | <p>Монгол улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө боловсруулахад шаардлагатай макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд, тэр дундаа нэгдсэн төсвийн орлого, зарлагын 2024 оны урьдчилсан гүйцэтгэл, 2025 оны төлөвлөгөөний дэлгэрэнгүй танилцуулга хүргүүлсэн болно. 2024 онд эдийн засгийн өсөлт, уул уурхайн экспортоос үүдэлтэйгээр төсвийн орлого мэдэгдэхүйц өссөн ч дэлхийн зах зээлийн эрсдэл, түүхий эдийн үнийн уналтаас хамааран орлогын биелэлт тасарч, төсвийн алдагдал гарсан бол зарлагын хувьд нийгмийн халамж, төрийн үйлчилгээний зардал бодлогоор нэмэгдэж, урсгал зардлыг өсгөсөн, зэрэг гүйцэтгэлийн учир шалтгааныг тайлбарласан болно.</p> <p style="text-align: right;">Хавсралт: 1 файл</p> | <p>1-р сар,<br/>2-р сар,<br/>3-р сар,<br/>4-р сар,<br/>5-р сар,<br/>6-р сар,<br/>7-р сар,<br/>8-р сар,<br/>9-р сар,<br/>10-р сар,<br/>11-р сар,<br/>12-р сар</p> | <p>100%</p> |
| 3   | <p>Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төслийг боловсруулахад шаардлагатай</p>   | <p>Тооцоо, төсөөллийн тусгасан танилцуулгын тоо</p> | <p>"Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль"-ийн</p>   | <p>Макро эдийн засгийн нөхцөл байдал, 2026 оны тооцоо, төсөөлөл,</p>               | <p>Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төслийг боловсруулах бэлтгэл ажлын хүрээнд улсын төсвийн орлого, зарлагын бодлогыг үндэслэн тодорхойлох зорилгоор макро эдийн</p>  | <p>1-р сар,<br/>2-р сар,<br/>3-р сар,<br/>4-р сар,<br/>5-р сар,</p>  | <p>100%</p> |

|   |   |                  |   |  |  |  |      |
|---|---|------------------|---|--|--|--|------|
|   | макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн тооцоо, төсөөллийн танилцуулгыг боловсруулна.                         |                  | танилцуулга д тооцоо, төсөөллийг хүргүүлсэн.  | тэргүүлэх чиглэлийн танилцуулгыг боловсруулсан байна.<br>/1 танилцуулга/               | засгийн үндсэн үзүүлэлтүүдийн төсөөллийг боловсруулсан болно. Уг төсөөлөл нь эдийн засгийн бодлого, гадаад орчны төлөв, дотоодын зах зээл, хөрөнгө оруулалт, хэрэглээ зэрэг хүчин зүйлсийг харгалзан олон улсын байгууллагуудын тооцоо, загварчлал, дотоодын статистик мэдээлэлд тулгуурлан боловсруулагдсан. Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн хувьд Улсын төсвийн суурь тоон үзүүлэлтүүдийн хүрээ, үүнд төсвийн орлого, зарлага, төсвийн тэнцэл засгийн газрын өрийн түвшин зэрэг үзүүлэлтүүдийн гүйцэтгэл, төсөөллийг боловсруулан хүргэсэн. Боловсруулсан макро эдийн засгийн төсөөлөл нь Монгол Улсын 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл болон төсвийн тухай хуулийн төслийг боловсруулахад суурь мэдээлэл болон ашиглагдах юм. Тус тооцоо, төсөөллийг Сангийн яаманд албан ёсоор хүргүүлсэн бөгөөд цаашид бодлогын түвшинд ашиглах боломжтой.<br><br>Хавсралт: 1 файл | 6-р сар,<br>7-р сар,<br>8-р сар,<br>9-р сар,<br>10-р сар,<br>11-р сар,<br>12-р сар   |      |
| 4 | Эдийн засгийн нөхцөл байдалд улирал (Macroeconomic diagnostics) тутам дүн шинжилгээ хийж, танилцуулга бэлтгэнэ. | Танилцуулгын тоо | Өмнөх онуудад эдийн засгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, улирал бүр тайлан бэлтгэсэн. | 2025 онд улирал бүр дүн шинжилгээ хийж танилцуулга бэлтгэсэн байна.<br>/4 танилцуулга/ | Монгол улсын макро эдийн засгийн нөхцөл байдал, тэр дундаа төсвийн гүйцэтгэл, өөрчлөлтүүд, тэдгээрийн шалтгаан, үр дагаврыг дэлгэрэнгүй танилцуулан хүргэдэг. 2024 оны 4-р улирлын танилцуулгад 2024 оны макро эдийн засгийг бүхэлд нь дүгнэх байдлаар, 2025 оны 1-р улирлын танилцуулгыг 2025 оноо төсөөлөх байдлаар боловсруулж, 2025 оны 2-р улирлын танилцуулгыг хэвлэн гаргаж УИХ-ын гишүүд болон сайд, макро эдийн   | 1-р сар,<br>2-р сар,<br>3-р сар,<br>4-р сар,<br>5-р сар,<br>6-р сар,<br>7-р сар,<br>8-р сар,<br>9-р сар,<br>10-р сар,<br>11-р сар,<br>12-р сар | 100% |

|  |   |                          |  |  |   |  |      |
|--|---|--------------------------|--|--|---|--|------|
|  |   |                          |  |  | засаг сонирхогчдод хүргүүлж, Эдийн засаг хөгжлийн яамны веб хуудас болон "MACRO channel MN" групп хаягт байршуулсан болно.<br>Хавсралт: 4 файл  |  |      |
| 5  | Макро эдийн засгийн богино, дунд хугацааны загваруудыг хөгжүүлж, эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн тооцоо, төсөөлөлд ашиглана.                  | Хөгжүүлсэн загварын тоо  | 2024 онд 3 загвар хөгжүүлсэн.  | Загвар хөгжүүлсэн байна.<br>/1 загвар/   | Засгийн газрын өр болон макро эдийн засгийн үзүүлэлтүүдийн дунд хугацааны (6 жил) төсөөлөл боловсруулах аргачлалыг хөгжүүлж байна. Тухайлбал, бодит ДНБ-г өсөлтийн дундаж, потенциал ДНБ-ий дундаж өсөлт, үйлдвэрлэлийн функц ашиглан төсөөлж байна. Харин төсвийн орлогыг мэдрэмжээс хамааруулан төсөөлөх, төсөөллийг тохируулгын утгаар засварлаж байгаа бол төсвийн зардлыг өсөлтийн хувиас хамааруулан төсөөлж, тохируулгын утгаар засварлаж байгаа гэх мэт төсөөллийн загваруудыг илүү боловсронгуй болгон хөгжүүлж байна.<br>Хавсралт: 2 файл | 1-р сар,<br>2-р сар,<br>3-р сар,<br>4-р сар,<br>5-р сар,<br>6-р сар,<br>7-р сар,<br>8-р сар,<br>9-р сар,<br>10-р сар,<br>11-р сар,<br>12-р сар | 100% |
| 3.3. Эдийн засгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, эдийн засагт тулгарч болзошгүй гадаад, дотоод эрсдэлийг тодорхойлох; |   |                          |  |  |   |  |      |
| 6  | Монгол Улсын эдийн засагт тохиолдож болзошгүй гадаад, дотоод эрсдэлийг тодорхойлж дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт тусгана. | Танилцуулга д туссан тоо | 2024 онд батлагдсан бодлогын баримт бичигт эдийн засагт тохиолдож болзошгүй эрсдэлийг тодорхойлж тусгасан. | Болзошгүй эрсдэлийг тодорхойлж, бодлогын баримт бичгүүдийн танилцуулгад тусгасан байна.<br>/2 танилцуулга/ | 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл болон 2026 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөний дэлгэрэнгүй танилцуулгад тусгасан. Төсвийн хүрээний мэдэгдлийн дэлгэрэнгүй танилцуулгын 4 дүгээр бүлэг болон УХЖТ-ний дэлгэрэнгүй танилцуулгын 2 дугаар бүлгийн 5 дугаар хэсэгт Худалдааны дайн, БНХАУ-ын эдийн засаг, ОХУ-Украины дайн, Уур амьсгалын өөрчлөлт, Эрчим хүчний тасралтгүй, найдвартай байдал, Зээлжих зэрэглэл буурах болон аливаа төрлийн   | 1-р сар,<br>2-р сар,<br>3-р сар,<br>4-р сар,<br>5-р сар,<br>6-р сар,<br>7-р сар,<br>8-р сар,<br>9-р сар,<br>10-р сар,<br>11-р сар,<br>12-р сар | 100% |

|  |   |                  |   |   |   |  |      |
|--|---|------------------|---|---|---|--|------|
|  |   |                  |   |   | хориг зэрэг олон улсын болон уур амьсгалын өөрчлөлтүүдийг тусгасан.<br>Хавсралт: 2 файл   |  |      |
| 7  | Макро эдийн засгийн голлох үзүүлэлтүүдийн статистикийн сарын гүйцэтгэлээр танилцуулга бэлтгэн, удирдлагыг тухай бүр мэдээллээр хангана.       | Танилцуулгын тоо | 2024 онд сар бүр танилцуулга бэлтгэсэн. | 2024 онд сар бүр танилцуулга бэлтгэсэн.<br>/12 танилцуулга/ | Макро эдийн засгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, удирдлагуудад үнэн зөв, нэгдсэн мэдээлэл өгөх зорилгоор сарын мэдээг бэлтгэн гаргадаг. Уг сарын мэдээний төсвийн хэсгийг боловсруулахдаа Сангийн яамны төсвийн гүйцэтгэлийн сар бүрийн нэгтгэл дээр тулгуурладаг бөгөөд тухайн сарын мэдээг дараа сард нь хүргэдэг. Төсөв хариуцсан мэргэжилтнүүдийн хувьд нэгдсэн төсвийн орлого, зарлага, тэнцэл засгийн газрын өр гэсэн үзүүлэлтүүдийг боловсруулан, онцгой өөрчлөлтүүдийг тэмдэглэн 2024 оны 12 сар болон 2025 оны 1-10 сарын мэдээг танилцуулсан. 2025 оны 11 сарын мэдээ 12 сарын 10 ирдэг тул хавсаргаагүй болно.<br>Хавсралт: 4 файл | 1-р сар,<br>2-р сар,<br>3-р сар,<br>4-р сар,<br>5-р сар,<br>6-р сар,<br>7-р сар,<br>8-р сар,<br>9-р сар,<br>10-р сар,<br>11-р сар,<br>12-р сар | 100% |
| 8  | Өдөр тутмын шуурхай мэдээлэл бэлтгэх, голлох бүтээгдэхүүнүүдийн үнийн мэдээллийн сан үүсгэж, удирдлагыг тухай бүр шуурхай мэдээллээр хангана. | Мэдээллийн тоо   | Түүхэн мэдээллийн сан үүсгэсэн          | Тухай бүр мэдээллээр хангасан байна.<br>/тухай бүр/         | Төсвийн үзүүлэлт тус бүрийн түүхэн мэдээллийг бэлтгэн excel хөгжүүлж байгаа. Энэ нь удирдлагуудад хэрэгцээтэй мэдээллүүдийг шуурхай хүргүүлэхэд чухал хүчин зүйлүүдийн нэг бодлог. Мөн удирдлагуудад цаг алдалгүй мэдээлэл хүргүүлэх зорилгоор Sharepoint дээр Power BI ашиглан өдөр тутмын түүхий эд болон экспортын үнэ, тоо хэмжээ, төсвийн мэдээг сар бүр update хийж шинэчлэгддэг байдлаар хийж гүйцэтгэсэн.<br>Хавсралт: 4 файл   | 1-р сар,<br>2-р сар,<br>3-р сар,<br>4-р сар,<br>5-р сар,<br>6-р сар,<br>7-р сар,<br>8-р сар,<br>9-р сар,<br>10-р сар,<br>11-р сар,<br>12-р сар | 100% |
| 3.4. Улсын эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжлийг хангах бодлогын шийдвэр гаргалтад дэмжлэг үзүүлэх зорилгоор судалгааг |   |                  |   |   |   |  |      |

хөгжүүлэхэд нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах;

|   |   |                              |   |  |   |  |             |
|---|---|------------------------------|---|--|---|--|-------------|
| 9 | <p>Дата баазууд боловсруулж эдийн засгийн судалгаанд ашиглана.<br/>(Гаалийн дата, И-баримт гэх мэт)</p> | <p>Тайланд ашигласан тоо</p> | - | <p>Улирлын тайланд ашигласан байна.<br/>/3 удаа/</p> | <p>Макро эдийн засгийн болон төсвийн орлогын 2025–2026 оны төсөөллийг боловсруулахдаа уул уурхайн салбар, тэр дундаа нүүрсний экспортын гүйцэтгэл, хэтийн төлөв нь онцгой нөлөө үзүүлдэг. Төсвийн орлогын голлох эх үүсвэр болох ААНОАТ, НӨАТ, онцгой албан татвар зэрэг татварын орлогын хэмжээнд нүүрсний экспортын биет хэмжээ, хилийн үнэ шууд хамааралтай тул, бодитой, суурь мэдээлэлд үндэслэн төлөвлөх нь чухал юм. Энэ хүрээнд Гаалийн ерөнхий газрын (ГЕГ) статистик тоон мэдээллүүдийг суурь параметр болгон төсвийн орлогын шинжилгээнд улирал бүр тогтмол ашигладаг. Тухайлбал, 2025 оны 1 дүгээр улирлын макро эдийн засгийн танилцуулгын шигтгээнд нүүрсний хилийн үнийн түүхэн мэдээлэлд тулгуурлан жилийн төсөвт тодотгол хийх нөхцөлийг тодорхойлсон болно. НӨАТ-ын дата баазад суурилж аж ахуйн нэгжийн борлуулалтын орлогын сар, улирлын давтамжтай дата, мэдээллээр мэдээллийн сан үүсгээд байна. Гааль, И-баримтын датаг сар бүр тогтмол авч аж ахуйн нэгжүүдийн борлуулалтын орлого, НӨАТ-ын шивсэн баримтын тоонд тооцоо, судалгаа хийж макро эдийн засгийн улирлын танилцуулгад оруулж, удирдлагыг холбогдох мэдээллээр тогтмол ханган ажиллаж байна. Мөн өрхийн худалдан авах чадварын индекс боловсруулах зорилгоор Санхүүгийн мэдээллийн технологийн төвтэй хамтран 4 дэлгүүрийн 6 барааны худалдан авалтын</p> | <p>1-р сар,<br/>2-р сар,<br/>3-р сар,<br/>4-р сар,<br/>5-р сар,<br/>6-р сар,<br/>7-р сар,<br/>8-р сар,<br/>9-р сар,<br/>10-р сар,<br/>11-р сар,<br/>12-р сар</p> | <p>100%</p> |
|---|---|------------------------------|---|--|---|--|-------------|

|    |   |                  |   |   |   |  |      |
|----|---|------------------|---|---|---|--|------|
|    |   |                  |   |   | дүнг И-баримтын тоон мэдээлэлд үндэслэн тодорхойлж, туршилт тооцоог боловсруулаад байна.<br>Хавсралт: 4 файл  |  |      |
| 10 | Монгол Улсын дунд төсвийн хугацааны эрсдэлийг тодорхойлж танилцуулга бэлтгэн богино, дунд хугацааны бодлогын баримт бичигт тусгана. | Танилцуулгын тоо | - | Танилцуулга боловсруулсан байна.<br>/1 танилцуулга/ | Төсвийн эрсдэлийн тайланд дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг боловсруулах хүрээнд төсвийн үзүүлэлтүүд анх төсөөлж байх үеийн суурь төсөөллөөс зөрөхөд нөлөөлж болзошгүй эрсдэлүүдийг тодорхойлж, улмаар эдгээр эрсдэлүүдээс сэргийлэх хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг тодорхойлов. Эрсдэлийг тодорхойлохдоо бид төсвийн харьцуулалт болон мэдрэмжийн шинжилгээнүүдийг хийж гүйцэтгэн төсөвт хамгийн их нөлөөлөх хүчин зүйлсийг тодорхойлсон. Мөн Тухайн эрсдэлүүдийн төсөвт үзүүлэх магадлал нөлөөллийн хэмжээ зэргийг эрсдэлийн зураглал ашиглан эрэмбэлэн тогтоож, эрсдэлийг бууруулах, удирдах арга хэмжээг тодорхойлсон болно. Эрсдэлийн тайланг 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэлтэй хамт Засгийн газарт өргөн мэдүүлж танилцуулсан болно. Хувилбарт тооцооллын үр дүнгээр худалдааны дайнтай холбоотой шокийн нөлөөгөөр манай улсын нийт экспортын орлого суурь төсөөлөлтэй харьцуулахад 2025 онд 1.7 тэрбум ам.доллараар, 2026 онд 2.9 тэрбум ам.доллараар тус тус буурч, улмаар төсвийн тэнцвэржүүлсэн орлого 2025 онд 1.3 их наяд төгрөгөөр, 2026 онд 1.8 их наяд төгрөгөөр тус тус буурч болзошгүй байна. Мөн экспортын гол нэр төрлийн бүтээгдэхүүн болох нүүрс, | 1-р сар,<br>2-р сар,<br>3-р сар,<br>4-р сар,<br>5-р сар,<br>6-р сар,<br>7-р сар,<br>8-р сар,<br>9-р сар,<br>10-р сар,<br>11-р сар,<br>12-р сар | 100% |

|   |   |                                   |   |  |  |  |      |
|---|---|-----------------------------------|---|--|--|--|------|
|   |   |                                   |   |  | зэсийн үнэ буурах, салбаруудын өсөлт төсөөллөөс бага байх, эрчим хүчний салбарын өсөлт төсөөллөөс бага байх, Засгийн газрын өрийн дарамт Хөрөнгө оруулалтын төсөл удааширч, он дамжих магадлал Дунд-Их байгаа бөгөөд тэдгээрийн төсөвт үзүүлэх нөлөө их байгаа бол уур амьсгалын өөрчлөлт, хөдөлмөрийн зах зээлийн эрсдэл Бага-Дунд, төсөвт үзүүлэх нөлөө дунд байна.<br>Хавсралт: 1 файл  |  |      |
| 3.5. Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг хуульд заасан зарчим, шаардлагыг баримтлан боловсруулах, олон нийтэд хэлэлцүүлэх; |   |                                   |   |  |  |  |      |
| 11  | Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг холбогдох хууль, журамд заасны дагуу олон нийтээр хэлэлцүүлэх арга хэмжээг зохион байгуулна. | Хэлэлцүүлэг зохион байгуулсан тоо | Монгол Улсын 2025 оны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг олон нийтээр хэлэлцүүлсэн | Олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулсан байна.<br>/1 хэлэлцүүлэг/ | Монгол Улсын "Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл"-ийн төсөл боловсруулахтай холбогдуулан Төсвийн тухай хууль 281.4 дэх заалт болон холбогдох журмын дагуу төсвийн төлөвлөлтөд төр, хувийн хэвшил, эрдэм шинжилгээ, олон улсын байгууллага, хэвлэл мэдээлэл, иргэдийн олон талт оролцоог хангах, тэдний санал, санаачилгыг төсөвт тусгах боломжийг бүрдүүлэх зорилгоор олон нийтийн хэлэлцүүлгийг 2025 оны 03 дугаар сарын 20-ны өдөр зохион байгуулсан. Түүнчлэн цахим орчинд нээлттэй санал, асуулга явуулж нийт 600 гаруй хариулт, 54 задгай санал хүлээн авсан байна. Мөн төсвийн хүрээний мэдэгдлийг тодотгосонтой холбоотойгоор цахим орчинд 2025 оны 8 дугаар сарын 05-ны өдрөөс 8 дугаар сарын 12-ны өдрийг хүртэл хугацаанд нээлттэй санал, асуулга явуулж нийт 300 гаруй хариулт, 17 задгай санал хүлээн авлаа. | 1-р сар,<br>2-р сар,<br>3-р сар,<br>4-р сар,<br>5-р сар,<br>6-р сар,<br>7-р сар,<br>8-р сар,<br>9-р сар,<br>10-р сар,<br>11-р сар,<br>12-р сар | 100% |

|    |   |                                     |   |  | Хавсралт: 3 файл  |  |      |
|----|---|-------------------------------------|---|--|---|--|------|
| 12 | Монгол Улсын нэгдсэн төсвийн дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулахад шаардлагатай макро эдийн засгийн болон төсвийн үндсэн үзүүлэлтүүдийн тооцоо, төсөөлөл, танилцуулгыг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн мэдүүлнэ. | Тооцоо, төсөөллийн танилцуулгын тоо | Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль | Макро эдийн засгийн нөхцөл байдал, 2026-2028 оны тооцоо, төсөөллийн танилцуулгыг боловсруулсан байна.<br>/1 танилцуулга/ | Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1-т “санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Стратегийн баримт бичгийн төслийг, эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс ирүүлсэн макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт, төлөв байдлын таамаглалд үндэслэн боловсруулж, жил бүрийн 04 дүгээр сарын 15-ны дотор Засгийн газарт хүргүүлэх” гэж, 8.1.3-т “Засгийн газар Стратегийн баримт бичиг, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг хэлэлцэн жил бүрийн 5 дугаар сарын 01-ний дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх” гэж, 8.1.4-т “Улсын Их Хурал Стратегийн баримт бичиг, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг жил бүрийн 6 дугаар сарын 01-ний дотор хэлэлцэж, батлах”, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1-д “дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг энэ хуулийн 11.1.3-т заасны дагуу тооцсон гол нэр төрлийн эрдэс баялгийн үнийг тусгаж тодорхойлсон төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ, төсвийн тусгай шаардлагад нийцүүлж хуульчлан батлах” гэж тус тус заасны дагуу, мөн Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт заасан тусгай шаардлагуудыг ханган Монгол Улсын нэгдсэн төсвийн | 1-р сар,<br>2-р сар,<br>3-р сар,<br>4-р сар,<br>5-р сар,<br>6-р сар,<br>7-р сар,<br>8-р сар,<br>9-р сар,<br>10-р сар,<br>11-р сар,<br>12-р сар | 100% |

|  |  |  |  |  |   |  |  |
|--|--|--|--|--|---|--|--|
|  |  |  |  |  | <p>2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг боловсрууллаа. Тус хуулийн төслийг холбогдох хуульд заасны дагуу 4 дүгээр сарын 15 дотор ЗГ-т, 4 дүгээр сарын 30 дотор УИХ-д өргөн барьж, Монгол Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө”-г хэлэлцэн 05 дугаар сарын 30-ний өдөр баталлаа. Мөн түүхий эдийн уналттай холбоотойгоор төсвийн хүрээний мэдэгдэлд тусгагдсан орлогын доод хязгаарт орлого хүрэхгүй байх нөхцөл байдал үүссэн тул тодотгож 2025 оны 11 дүгээр сарын 12-нд УИХ-аар дахин батлагдсан.</p> <p style="text-align: right;">Хавсралт: 1 файл</p> |  |  |
|--|--|--|--|--|---|--|--|

#### НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

| № | Үүрэг даалгавар | Өгсөн субъект | Биелэлт |
|---|-----------------|---------------|---------|
| 1 | 2               | 3             | 4       |

#### ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| №   | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин |              |   |                          |                 |
|---|----------------------------------|------------------|---------------------|--------------|---|--------------------------|-----------------|
|   |                                  |                  | Суурь түвшин        | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт                       | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|   | 1                                | 2                | 3                   | 4            | 5   | 6                        | 7               |
| 4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх |                                  |                  |                     |              |   |                          |                 |
| 1   | Хариуцсан                        | Хариуцсан        | Хариуцсан           | Хариуцсан    | Олон улсын валютын сангийн макро эдийн засаг, | 1-р сар,                 | 100%            |

|   |   |   |  |  |  |  |      |
|---|---|---|--|--|--|--|------|
|   | чиг үүргийнхээ хүрээнд сургалт, семинар, хэлэлцүүлэгт оролцсон байх | чиг үүргийнхээ хүрээнд сургалт, семинар, хэлэлцүүлэгт оролцсон байх | чиг үүргийнхээ хүрээнд сургалт, семинар, хэлэлцүүлэгт оролцсон байна. 100% | чиг үүргийнхээ хүрээнд сургалт, семинар, хэлэлцүүлэгт оролцсон байна. 100% | төсөвтэй холбоотой цахим, үнэ төлбөргүй сургалтуудад бүрэн хамрагдсан. Монгол улсад алтны арилжаа, хадгаламжийн үйлчилгээний хууль эрх зүйн орчныг судлах зорилгоор Голомт банкны Алтны арилжааны хэлтсийн даргатай уулзаж санал бодлоо солилцсон. 2025 оны 4 сард Нэгдсэн бодлого төлөвлөлтийн газрын Дэлхийн банкттай хийсэн уулзалтад Макро бодлогын газрын төлөөлөн оролцсон. Уулзалтын хүрээнд дэлхийн банкны зүгээс монгол улсын макро эдийн засаг, хөгжил, тэр дундаа ядуурал, татварын ачаалал зэрэг чухал сэдвүүдийг хөндөн хийсэн судалгаатай танилцаж, санал хүсэлтээ солилцсон болно. 2025 оны 5-р сарын 6-нд Олон улсын валютын сангийн дүрмийн IV заалтын дагуу ажиллаж буй ажлын хэсэгтэй уулзан макро эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдал, төсөөлөл, гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлж буй арга хэмжээг танилцуулж, тэдний санал, зөвлөмжийг авсан. Мөн төсвийн зарцуулалт, үүсэж болох эрсдэлээс сэргийлэх, удирдах зэрэг эдийн засаг төсвийн асуудлаар санал солилцож, туршлага, мэдлэг хуримтлуулсан. 2025 оны 8 дугаар сарын 25 аас 9 дүгээр сарын 12 ны хооронд Олон улсын валютын сангийн Macroeconomic Diagnostics, Fiscal Rules and Frameworks гэсэн сургалтад хамрагдсан. Мөн 2025 оны 12-р сарын 01-05-ны өдрийн хооронд зохион байгуулагдсан Public Debt and Medium-Term Macroeconomic Framework Tool сургалтад хамрагдсан.<br>Хавсралт: 1 файл | 2-р сар,<br>3-р сар,<br>4-р сар,<br>5-р сар,<br>6-р сар,<br>7-р сар,<br>8-р сар,<br>9-р сар,<br>10-р сар,<br>11-р сар,<br>12-р сар |      |
| 2 | Яамнаас зохион байгуулсан мэдээллийн цагт тогтмол хамрагдсан        | Яамнаас зохион байгуулсан мэдээллийн цагт тогтмол хамрагдсан        | Яамнаас зохион байгуулсан мэдээллийн цагт тогтмол хамрагдсан               | Яамнаас зохион байгуулсан мэдээллийн цагт тогтмол хамрагдсан               | 2025 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 11:00-12:00 цагийн хооронд Монгол Улсын Ёс зүйн хорооны Соён гэгээрүүлэх хэлтсийн дарга Ц.Заяхүү, референт З.Соёлмаа нарын Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн талаар сургалтад Төрийн албаны тухай хуулийн 37   | 1-р сар,<br>2-р сар,<br>3-р сар,<br>4-р сар,<br>5-р сар,<br>6-р сар,   | 100% |

|  |      |      |             |             |   |  |  |
|--|------|------|-------------|-------------|---|--|--|
|  | байх | байх | байна. 100% | байна. 100% | <p>дугаар зүйлийн 37.1.7, 37.1.8 дахь заалтад заасан үүргээ биелүүлж тус сургалтад хамрагдлаа. 2025 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 09:00-09:40 цагийн хооронд хяналт шинжилгээ, үнэлгээний газраас зохион байгуулсан мэдээллийн цагаар Зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээний тухай сэдвээр С.Солонго, Н.Насанжаргал нарын сургалтад оролцлоо. 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 8:00-9:05 цагийн хооронд Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн дэд захирлын "Ажил, амьдралын тэнцвэр" сэдэвт сургалтад оролцлоо. 5-р сарын 23-нд шинээр томилогдсон албан хаагчдад зориулсан Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн комиссар Н.Батчулууны "Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай" сургалтад хамрагдсан. Мөн 2025 оны 10 сараас 1. Хиймэл оюун ба хэрэглээ, түүнийг хэрхэн үр дүнтэй ашиглах 2. Мал эмнэлгийн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн чадавх, судалгааны үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэх боломж 3. Healthy is the new cool 4. Эдийн засгийн албаны үүсэл, хөгжлийн түүх 5. Хувь хүний хөгжлийг дэмжих багаар ажиллах ур чадвар зэрэг Газар тус бүрийн зохион байгуулсан сургалтад хамрагдсан.</p> | <p>7-р сар,<br/>8-р сар,<br/>9-р сар,<br/>10-р сар,<br/>11-р сар,<br/>12-р сар</p> |  |
|--|------|------|-------------|-------------|---|--|--|

ХЯНАСАН:

Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга, Отгондэмбэрэл Мягмардорж /...../

Огноо: 2025.12.12

ТАЙЛАН ГАРГАСАН:

Засгийн газрын өр хариуцсан мэргэжилтэн, Тамир Мөнхцэцэг /...../

Огноо: 2025.12.12

